



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН НЭРЭМЖИТ ШАТРЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ-2025 ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

2025 оны 08 дугаар
сарын 27-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Тэмцээний зорилго

1.1.Хуульчдын дунд оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, тэдгээрийн ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцоход оршино.

Хоёр. Хамрах хүрээ, зохион байгуулалт

2.1.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуульчид улсын зэрэг, цол, хүйс харгалзахгүй тэмцээнд оролцоно.

2.2. Хороод тус бүр нийт 3 хүний бүрэлдэхүүнтэй 1 баг оролцуулах ба 1, 2 дугаар ширээнд эрэгтэй хуульч, 3 дугаар ширээнд эмэгтэй хуульч тоглоно.

2.3.Тэмцээний зорилготой уялдуулан Монголын Хуульчдын холбооны гишүүн бус шатарчдыг оролцуулах боломжгүй.

Гурав. Тэмцээн болох газар, зохион байгуулах хугацаа

3.1.Тэмцээнийг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр “Хуульчдын ордон”-ы 17-р давхрын “Хуульчдын танхим”-д зохион байгуулна. Тэмцээн тухайн өдрийн 09:30 цагт эхэлнэ.

Дөрөв. Тэмцээн зохион байгуулах журам

4.1.Тэмцээнийг Олон улсын шатрын холбоо болон Монголын шатрын холбооны дүрмийн дагуу зохион байгуулна.

4.2.Тэмцээн шатрын рапид төрлөөр явагдана.

4.3.Тэмцээнийг швейцарь системээр явуулж, 7-9 өрөг тоглуулна.

4.4.Тэмцээнд шатрын мэргэжлийн шүүгчдийн баг ажиллана.

4.5.Тэмцээний дүн, мэдээ, цувааг онлайнаар олон улсын шатрын уралдаан, тэмцээний сайт (chess-results.com)-д байршуулна.

4.6.Хожсон ба тэнцсэн баг шүүгчид оноогоо заавал хэлж, тэмдэглүүлэх үүрэг хүлээнэ.

4.7.Гар утас, ухаалаг төхөөрөмжийг дуугүй горимд байлгаж, тэмцээнд оролцоно.

4.8.Тоглолтын танхимд тамхи татах, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглоно.

4.9.Тэмцээний Ерөнхий шүүгчийн шийдвэр эцсийн бөгөөд түүнтэй үл маргалдана.

4.10.Цагийн хяналт талдаа 20 минут байна.

4.11.Оноо тэнцсэн тохиолдолд дараах үзүүлэлтийг харгалзана.

А.Хоорондын тоглолт

Б.Бухкольц

В.Бергер

Г.Цэвэр хожлын тоо

Д.Хараар тоглосон үзүүлэлт

Тав. Тэмцээний бүртгэл

Тэмцээнд оролцогч шатарчид 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 17:00 цагаас өмнө мэдүүлгээ Монголын Хуульчдын холбооны хороо хариуцсан мэргэжилтний цахим хаяг руу илгээснээр бүртгэл баталгаажна. Мэдүүлэг дэх мэдээлэл дутуу тохиолдолд бүртгэхгүй. Мэдүүлгийн загварыг хавсаргав.

Зургаа. Шагнал урамшуулал

Онооны дарааллаар;

- 1 дүгээр байр-Цом, алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал;
 - 2 дугаар байр-Мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал;
 - 3 дугаар байр-Хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал;
 - 4 дүгээр байр- Өргөмжлөл, мөнгөн шагнал;
 - 5 дугаар байр- Өргөмжлөл, мөнгөн шагнал;
- Ширээ тус бүрийн тэргүүн байр-өргөмжлөл, мөнгөн шагнал;
Шилдэг ахмад шатарчин(55-аас дээш насны шатарчин 1 хүн)-Өргөмжлөл, мөнгөн шагнал;
Шилдэг эмэгтэй шатарчин(1 хүн)- Өргөмжлөл, мөнгөн шагнал;
Рейтинггүй шатарчин(1 хүн)- Өргөмжлөл, мөнгөн шагнал;
Хуульчдын холбооны Тамгын газрын шилдэг шатарчин-Өргөмжлөл, мөнгөн шагнал.
Шагналыг давхардуулж олгохгүй.

Долоо. Холбоо барих утас

Монголын Хуульчдын холбооны хороо хариуцсан мэргэжилтэн Т.Гүнбилэг,
Утас:95800707, имэйл хаяг: Gunbileg.work@gmail.com

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН
БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО**

ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ТАМИРЧНЫ МЭДҮҮЛГИЙН ЗАГВАР

№	Овог, нэр	Ажлын газар, албан тушаал	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн дугаар	Татвар төлөгчийн дугаар	Холбоо барих утасны дугаар
1					
2					
3					